



ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2022 оны 07 сарын 21 өдөр

Дугаар 49

Мандалговь

Г.Цэвэлмааг Татварын хэлтсийн Өндөршил  
сумын татварын улсын байцаагчийн  
албан тушаалд нэр дэвшүүлэх тухай


Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн тус аймаг дахь салбар зөвлөлийн 2022 оны 5 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Аймгийн Татварын хэлтсийн Өндөршил сумын татварын улсын байцаагчийн албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад Ганболдын Цэвэлмаа 49.0 оноогоор тэнцсэн тул тухайн албан тушаалд нэр дэвшүүлсүгэй.

Хоёр Ажлын байрны шаардлагыг хангаж байгаа Г.Цэвэлмааг холбогдох материалыг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэхийг салбар зөвлөлийн ажлын албанд даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Ш.ТӨРБАТ





**Татварын хэлтсийн Өндөршил сумын татварын  
улсын байцаагчийн албан тушаалд нэр дэвшүүлсэн  
Г.Цэвэлмаагийн тухай дүгнэлт**

1. Г.Цэвэлмаа нь 1999 онд Дундговь аймгийн Өндөршил суманд төрсөн. 23 настай, эмэгтэй
2. Боловсрол: 2017-2021 онд Олон улсын эдийн засаг, бизнесийн их сургуулийг банк, санхүү, нягтлан бодох бүртгэл мэргэжлээр бакалаврын зэрэгтэй суралцаж төгссөн.
3. Г.Цэвэлмаагийн тухайн ажлын байрны ерөнхий болон тусгай шаардлагыг хангаж байгаа болон тухайн албан тушаалын сонгон шалгаруулалтад тэнцсэн зэргийг харгалзан Татварын хэлтсийн Өндөршил сумын татварын улсын байцаагчийн албан тушаалд томилуулах санал, дүгнэлтийг гаргаж байна.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛ